

**АЙМГИЙН ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

2019.01.10

№ 01

Алтай хот

№	Хэлэлцэх асуудал	Хэн хэлэлцүүлэх	Хэн байлцах	Гарах шийдвэр
1	Дэд зөвлөл байгуулах тухай	Ч.Цогбаяр		Тогтоол 01
2	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийг ажлаас нь халах тухай	Л.Батжаргал		Тогтоол 02
3	ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч томилох тухай	Л.Батжаргал		Тогтоол 03

**ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
АЖЛЫН АЛБА**



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 01 сарын 10 өдөр

Дугаар 01

Есөнбулаг сум

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг
хангах дэд зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалт, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсгийг үндэслэн тус тус ТОГТООХ нь:

1. Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дэргэд ажиллах Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах дэд зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дэд зөвлөлийн дарга: ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга: Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн дарга

Гишүүдэд: Аймгийн Прокурорын газрын Ерөнхий прокурорын орлогч

Есөнбулаг сумын Засаг дарга бөгөөд Алтай хотын захирагч

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга

Автотээврийн үндэсний төвийн дарга

Аймгийн Мэргэжлийн Хяналтын Газрын Автотээвэр, өргөх

механизмын хяналтын улсын байцаагч

Алтай хотын тохижилт үйлчилгээний газрын дарга

ГАА-АЗЗА ХК-ны захирал

Цагдаагийн газрын Олон нийттэй харилцах ахлах байцаагч

Албан журмын даатгуулагчдын холбооны дарга

2. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах дэд зөвлөлийн дарга, бүрэлдэхүүнд ДААЛГАХ НЬ:

- Дэд зөвлөлийн ажиллах журам, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар 2019 оны 2 дугаар сард багтаан батлуулах

- Дэд зөвлөлийн үйл ажиллагааг жил бүрийн дөрөвдүгээр улиралд багтаан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллах

ДАРГА  БАТЖАРГАЛ





ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 01 сарын 10 өдөр

Дугаар 02

Есөнбулаг сум

ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн
бичгийн даргын үүргийг түр орлон
гүйцэтгэгчийг албан тушаалаас нь
халах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.6 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.1.3 дахь заалтуудыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Мөнхтөрийг албан тушаалаас нь халсугай.

2. А.Мөнхтөртэй цалин, эд, аж ахуйн тооцоог хийж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ажлын албаны нягтлан бодогч /Г.Соёлоо/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА  Д.БАТЖАРГАЛ





ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 01 сарын 10 өдөр

Дугаар 03

Есөнбулаг сум

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн
бичгийн даргын үүргийг түр орлон
гүйцэтгэгч томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.6 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.8, 43 дугаар зүйлийн 43.3.3 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 264 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр Алтангэрэлийн Амарзаяаг томилсугай.

2. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдсон А.Амарзаяагийн цалинг ТЗ-11-5 шатлалааар тогтоож, холбогдох нэмэгдлийг хууль, журмын дагуу олгохыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ажлын албаны нягтлан бодогч /Г.Соёлоо/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА  БАТЖАРГАЛ